



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А382

Булган сум

**“Алтаргана 2024” наадмын бэлтгэл ажлын хүрээнд  
Биеийн тамир, спортын газрын “Б” заалны гадна  
засварын ажилд хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын бэлтгэл ажлын хүрээнд Биеийн тамир, спортын газрын “Б” заалны гадна засварын ажилд 19,340,000 (арван есөн сая гурван зуун дөчин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Гэрээ байгуулах эрхийг Биеийн тамир, спортын газрын дарга (Х.Батхишиг)-д олгож, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.


3. Дээрх хөрөнгийг хавсралтаар баталж, орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010491

Аймгийн Засаг даргын 2024 оны  
05 дугаар сарын 24-ны/ний өдрийн А.382 дугаар  
захирамжийн хавсралт



“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын бэлгэл ажлын хүрээнд Биеийн тамир,  
спортын газрын “Б” заалны гадна засварын ажлын зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	1	2	3	4
1	Биеийн тамир, спортын газрын “Б” заалны үүдэн хэсгийн засварын будаг	-	12,500,000	12,500,000
2	Биеийн тамир, спортын газрын “А” заалны хөшиг	150м	10,000	1,500,000
3	Биеийн тамир, спортын газрын “Б” заалны сандал	24 ш	222,500	5,340,000
Нийт үнэ				19,340,000